

ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ТАЙЛАН

2023.09.05

Баян-Улаан

Монгол улсын Засгийн газраас 2022 оныг "Хоршооны хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан төр хоршооллын хамтын ажиллагааг өргөжүүлэх, төрөөс хоршооны талаар баримталж буй бодлого арга, хэмжээг сурталчлах, хоршоодыг идэвхжүүлэх зорилгоор сумын хоршооны хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, худалдаа, ахуйн үйлчилгээний хангамж, чанарыг сайжруулах чиглэлээр сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг батлуулж, ХХААХҮСайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 тушаалаар батлагдсан "Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, ханалт тавих журам"-ын дагуу төсөл сонгон шалгаруулах хороо болон хяналтын зөвлөлийг ИТХ-аар батлуулан хоршоог хөгжүүлэх сангийн төслийг зарлах, хүлээн авах товыг тогтоолгон 09 дүгээр сарын 01 нд ХХСангийн ТСШХороо хуралдаж 80,0 сая төгрөгний зээлийг Өв борх хоршоо нэхий, хоёрдогч түүхий эд боловсруулах чиглэлээр 20,0сая, Сүүн залаа хоршоо бэлчээр хадлангийн талбай хашиж хамгаалж, хоршооны үйл ажиллагааг өргөжүүлж, гишүүдийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр 20,0сая, Өрнөх Дөлгөөн хоршоо Баянгол омгийн үржлийн эм хонь, хуцаар малын үүлдэр угсааг сайжруулах чиглэлээр 10,0 сая, Баянхоолойн буян хоршоо мал мах, малын гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлэх чиглэлээр 30,0 сая төгрөгний хөнгөлөлттэй зээлд тус тус хамрагдан үйл ажиллагаагаа явуулж байна. ХХСангийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу төлүүлэх, мэдээллийн санд оруулж, мэдээлэх, хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар санд 25.5 сая төгрөг төвлөрөөд байна.

2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн ИТХ-ын хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу Сум хөгжүүлэх сангаас зээл авсан ААН, хоршоо, иргэдийг мэдээллээр ханган, арга зүйн зөвөлгөө өгч ажилласан бөгөөд шалгалтанд 4 хоршоо, 2 ААН, 22 иргэн хамрагдсан бөгөөд зээлдэгч нар журмын дагуу үйл ажиллагаагаа эрхэлж, үйлдвэрлэл, үйлчилгээгээ явуулж өрхийн орлогоо нэмэгдүүлж, шинээр ажлын байр бий болгон амжилттай ажиллан, сум болон аймгийн үзэсгэлэн худалдаанд амжилттай оролцож байна. Явцын хугацаа хэтрэлттэй 5 иргэнд албан мэдэгдэл хүргүүлсэн бөгөөд 3 зээлдэгч зээлээ мэдэгдэлийн хугацаанд төлсөн.

ХХСангийн хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх талаар зээлдэгч нарт тухай бүр нь мэдэгдэл өгч зээлээ төлөх талаар анхааруулж ажиллаж байна. 2023 онд ИХАШШүүх рүү шилжүүлсэн ХХСангаас зээл аваад зээлийн гэрээний хугацаа бүрэн дууссан 2 зээлдэгчийн 17.050,0 төгрөг бүрэн төлөгдөж санг хохиролгүй болгосон. 2023 онд ХХСангаас 100,0 сая төгрөгийн зээлийг сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлийн дагуу үйлдвэрлэл үйлчилгээ явуулж байгаа хоршоо, ААН, иргэнд олгохоор төлөвлөсөн бөгөөд 2023 оны 06 дугаар сард 50,0 сая төгрөгийн зээлийг “Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх” зорилтот жилийн хүрээнд хүнсний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 7 иргэнд олгосон бөгөөд 10 дугаар сарын 04 нд ХХСангийн журамд өөрчлөлт орж 50,0сая - төгрөгний зээлийг гаргаагүй. ХХСангаас зээл авсан хоршоо, ААН, иргэдэд ИТХ болон ХХСангийн хяналтын зөвлөлтэй хамтран хяналт шалгалтыг зохион байгуулж зээлээ журмын дагуу зориулалтаар ашиглаж, үйлдвэрлэл үйлчилгээгээ явуулж байгаад байнгын хяналт хийж, явцын хугацаа хэтрэлттэй болон гэрээний хугацаа дууссан зээлдэгч нарт албан мэдэгдэлийг тухай бүр өгч зээлүүдийг шүүхийн байгууллага руу шилжүүлэн Х.Х.Сангийн эргэн төлөлтийг сайжруулан сангийн хөрөнгийг төвлөрүүлэн жил бүр 80.0-150.0 сая төгрөгийн зээлийг гарган ажиллаж байна.

Жич: - Холбогдох зурагнууд

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГА

Б.БААСАН


ТАЙЛАН БИЧСЭН:

ХЖДҮХАХМЭРГЭЖИЛТЭН


Ш.МӨНСАЙХАН

Тайланд холбогдох зурагнуудыг хавсаргав.

ХХСангаас өөрсдийн үйлдвэрлэл, үйлчилгээг сайжруулах, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжөө шинэчлэх, өрхийн орлогоо нэмэгдүүлэх зорилгоор зээлэнд хамрагдсан иргэд сумын Бизнес хөгжлийн төвд байрлан үйл ажиллагаагаа явуулж байна.




Гэрэл зураг, компьютер, канон, оёдол, сүү цагаан идээ боловсруулах чиглэлээр зээлэнд хамрагдсан иргэд





Гэрийн мод, модон тавилга, эсгий урлал, сур, суран эдлэлийн чиглэлээр зээлэнд хамрагдсан иргэд





Газар тариалангийн чиглэлээр зээлэнд хамрагдсан ААН, хоршоо, иргэд





Зөгийн аж ахуй болон мод үржүүлэгийн аж ахуй эрхлэгч Б.Ганбат

